

НИСЭХИЙН МЭДЭЭЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2020.08.07

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2020 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн ИНҮТ-ийн харьяа Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 18/20 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны менежер П.Батсайхан, аудитор П.Цогбаяр, Т.Саранчимэг, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Ц.Оюут нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг дотоод аудит, хяналт шалгалтын ажлыг хугацаанд нь гүйцэтгэсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албаны 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацааны захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаа, үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, цалин хөлсний бүртгэл тооцоо зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Нисэхийн мэдээллийн үйлчилгээний үйл ажиллагааны ерөнхий журмын ЖУ-1-ийн 2.3.1, 2.3.5-д ...“туслахаар ажиллаж” гэж заасан нь ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журамд заасан нэр томъёотой нийцэхгүй байна.

Тус албанд шинээр ажилд орсон ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулахдаа туршилтын болон дадлагын хугацааг зааж өгөөгүйгээс ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журамд заасан туршилтын болон дадлагын хугацаа дууссан байхад ажилтан тухайн ажлын байранд ажиллах эрх аваагүй байна.

НМҮА-ны ажилтнууд цалинтай чөлөө авахдаа Хөдөлмөрийн дотоод журмын 5.3.1.2-д заасан холбогдох баримтыг бүрдүүлж өгөөгүй, өргөдлийг хянаж шийдвэрлэх ажилтан нь холбогдох баримтыг шаардаж бүрдүүлээгүй байна.

Ажлын цагийн тооцоонд ажилтнууд чөлөө авсан нь тэмдэглэгдээгүйгээс ажилтнуудын чөлөөтэй байсан хугацаанд хоолны мөнгө олгосон. Мөн ажлын цагийн тооцоонд ажилтнуудыг цалинтай чөлөө авсныг тэмдэглэсэн байтал нягтлан бодогч хоолны мөнгө олгосон зөрчил байна.

Төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэн ажиллуулах тухай ИНЕГ-ын даргын гаргасан А/205 дугаар тушаалд заасан ...Ажилтнуудыг илүү цагаар ажиллуулахгүй байхаар ажлын цагт зохицуулалт хийх, илүү цагаар ажиллуулсан тохиолдолд биеэр нөхөн амраах, биеэр нөхөн амраах боломжгүй нисэхийн аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд шууд оролцдог ээлжийн ажилтнуудын илүү цагийг ИНҮТ-өөр хянуулж шийдвэрлүүлэх... гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй.

Албан бичгийн төслийг боловсруулсан болон хянасан, нийлсэн ажилтнууд Архивын ерөнхий газрын даргын 2009 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 68 дугаар тушаалаар баталсан “Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”, Зохион байгуулалт, захирамжлалын

баримт бичгийн MNS 5140:2011 стандарт, “Баримт бичиг боловсруулсан тухай тэмдэглэлийн бүрдэл”-ийг хангаж ажиллаагүй байна.

Тус албаны тухайн ажлыг хариуцсан ажилтнууд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаал, “Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 253 дугаар тушаал, ИНЕГ-ын даргын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/688 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үзлэг, гурван шатны хяналтыг зохион байгуулах журам”-ыг өөрийн албан дээр хэрэгжүүлж ажиллахдаа хууль болон тушаалын заалт нэг бүрийг хэрэгжүүлэх талаар анхаарч ажиллаагүй байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлын засаж, залруулах талаар Иргэний нисэхийн ерөнхий газрын Захиргаа, удирдлагын газарт 1, Иргэний нисэхийн үндэсний төвд 2, тус албанд 7, нийт 10 зөвлөмж өгсөн болно.

ДОТООД АУДИТЫН АЛБА